



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А1102

Чойр

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор арга хэмжээ зохион байгуулж явуулах ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэг, Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/73 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудад цэрэг- эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит аварга шалгаруулах Цэрэг-Спортын “Дөл” цогцолбор арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулсугай.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Дөл” цогцолбор арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр, тэмцээний удирдамжийг хоёрдугаар, зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Дөл” цогцолбор арга хэмжээний удирдамж, зааврыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэн, үүрэг чиглэл, зааварчилгааг тогтмол өгч, бэлтгэлийг хангуулан үр дүнг тайлагнаж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Б.Баянмөнх), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Уранцэцэг), Боловсрол, шинжлэх ухааны газар (А.Зургаанжин)-т тус тус даалгасугай.

4. “Дөл” цогцолбор арга хэмжээний удирдамж, заавар, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад дүрэм журмыг мөрдүүлж ажиллахыг аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын захирал нарт хариуцуулсугай.


5. Арга хэмжээ зохион байгуулж явуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Хурандаа Х.Сүхбаатар), Нэгдсэн эмнэлэг (У.Ариун-Эрдэнэ), Биеийн тамир, спортын газар (Л.Буянтогтох), Боржигин чуулга (Ц.Цэнджав)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Засаг даргын 2022 оны 04
дүгээр сарын 08 -ны өдрийн 11/08 дугаар
захирамжийн 1 дүгээр
хавсралт



ЦЭРЭГ СПОРТЫН “ДӨЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Содном

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
дарга

Ажлын хэсгийн орлогч:

Б.Баянмөнх

Цэргийн штабын дарга, хурандаа

Гишүүд:

С.Уранцэцэг

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Х.Сүхбаатар

Онцгой байдлын газрын дарга,
хурандаа

У.Ариун-Эрдэнэ

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга

Л.Буянтогтох

Биеийн тамир, спортын газрын дарга

Ц.Цэнджав

Боржигин чуулгын дарга

А.Зургаанжин

Боловсрол, шинжлэх ухааны газрын
дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Оюунбат

Цэргийн штабын тоо бүртгэлийн
офицер, ахмад

Аймгийн Засаг даргын 2022
оын 04 дүгээр сарын 01-ны
өдрийн 1/м дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 101
ЖИЛИЙН ОЙ, ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 77 ЖИЛИЙН ОЙГ
ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ”
ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго:

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх, Монгол Улсын Батлан хамгаалах салбар, түүний үйл ажиллагаа болон цэргийн албыг сурталчлах, мэдээлэл танилцуулгыг хүргэх, эр цэргийн алба хаах хүсэл сонирхолыг төрүүлэхэд оршино.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад оролцогч байгууллага:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб
- Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс
- Аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар
- Аймгийн онцгой байдлын газар
- Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

Гурав. Тэмцээн явуулах хугацаа, байрлал:

3.1. Цэрэг спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээн 2 үе шатаар зохион байгуулагдах ба I шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 4 дүгээр сард зохион байгуулж I шатнаас шалгарсан тасгийг II шат буюу 2022 оны 08 дугаар сард зохион байгуулагдах Улсын аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэн оролцуулна.

3.2. Тэмцээний I шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагт Биеийн тамир спортын газар зохион байгуулах ба уг тэмцээний үеэр Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулна.

3.3. Дасгалжуулагч багш нарын урьдчилсан техникийн зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 16.00 цагт аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгуулна. I шатанд оролцох сурагчдын мэдүүлэг, хувийн хэрэг, сурагчдын сүүлийн

2 сарын хугацаанд авхуулсан 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зурагтай Цэргийн штабт бүртгүүлж мандат авна.

3.4. II үе шат: Улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээний бэлтгэлийг 2022 оны 08 дугаар сарын 10-24-ний өдрүүдэд, тэмцээнийг 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд “Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв”-ийг түшиглэн тус тус явуулна. /Шагналт байрт шалгарсан сурагчдаас сонгон шалгаруулж Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулна./

3.5. Энэхүү тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулна.

Дөрөв. Тэмцээний ерөнхий зохион байгуулалт:

4.1.Тэмцээний нэгдүгээр шатанд Ерөнхий боловсролын сургуулиас тус бүр 2 тасаг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд (8 тасаг) оролцож, шагналт байранд шалгарсан тасгуудаас II шатанд буюу улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд оролцоно.

4.2.Тасаг нь Ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн 16-17 насны 11 (7 эрэгтэй, 4 эмэгтэй) гишүүнтэй байх бөгөөд нөөц эрэгтэй-1, эмэгтэй-1 гишүүнтэй байна. Тасгийн бүрэлдэхүүн өөрийн онцлогийг харуулсан таних тэмдэг бүхий дүрэмт хувцас, дүрэмт хувцасны загварт тохирсон хагас түрийтэй гутлаар жигдэрсэн байх ба тамирчид модоор хийгдсэн АК буутай байна. Мөн тасгийн 1 гишүүн эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнхтэй байна. Эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнхэнд дараах эм, эмнэлгийн хэрэгсэл байна.

Үүнд:

- 4.2.1.хуруу лент 100 ширхэг,
- 4.2.2.ариун наалт 10 ширхэг,
- 4.2.3.иодтой савх 10 ширхэг,
- 4.2.4.спирттэй арчдас 10 ширхэг,
- 4.2.5.өвчин намдаах тос 1 ширхэг (диклоденк 29/-65 гр),
- 4.2.6.өвчин намдаах эм 1 ширхэг (диклоденк 50 мг),
- 4.2.7.уян боолт хэмжээ тус бүрээс 3 ширхэг,
- 4.2.8.мөчдийн уян чиг 2 ширхэг,
- 4.2.9.цус тогтоох чангалуур 2 ширхэг (хугацаа тавигчтай),
- 4.2.10.тэмдэглэлийн дэвтэр, бал 1 ком (жижиг),
- 4.2.11.гялгар уут (бахардсан тохиолдолд үлээлгэх зориулалттай),
- 4.2.12.амны хаалт, үзлэгийн бээлий тус бүр 10 ширхэг,
- 4.2.13.гар ариутгагч 1 ширхэг (жижиг).

4.3.Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд (цаашид “Тэмцээнд” гэх) оролцох тасгийг ерөнхий боловсролын ахлах сургуулиуд хариуцан оролцуулах ба тасаг бүр дасгалжуулагч-багш /ЕБС-ийн Биеийн тамирын/-тай байх ба дасгалжуулагч-багш нь сурагчдын тэмцээнд бэлтгэн оролцох хугацааны хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

4.4.Тэмцээнд оролцох тасгийн бүрэлдэхүүнийг нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж Эрүүл мэндийн төвийн Ерөнхий

эмчийн дүгнэлт гаргуулсан байх бөгөөд гишүүн бүр коронавирусийн вакцинд хамрагдаж, гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна. Тэмцээний явцад томилогдсон эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнууд тэмцээнд оролцогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавина.

4.5.Тасгийн гишүүд өөрийн багийн онцлогийг тусгасан 8 см голч бүхий ялгаж тэмдгийг зүүн энгэртээ зүүсэн байна. Тасгийн чиглүүлэгч нь 40х40 см-ийн хэмжээтэй тасгийнхаа онцлогийг илэрхийлсэн дарцагтай байна.

4.6.Тасаг бүр сургуулийн туг, далбаатайгаар тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд зохион байгуулалттай оролцоно. Туг, далбааны хэмжээ 2.0х1.0 метрийн хэмжээтэй байна.

Тав. Тэмцээнийг үнэлэх журам:

5.1.Тэмцээний явцад биелүүлэх дасгал, нормативыг дараах баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, үнэлэх журмын дагуу үнэлнэ. Үүнд:

5.1.1.Цогцолбор тэмцээний заавар /хавсрагдсан/,

5.1.2.Цэргийн биеийн тамирын заавар, ЗХЖШ, ЦБТЗ-2018 он,

5.1.3.Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, ЗХЖШ, 2017 он.

Зургаа. Дүн гаргах, шагнал урамшуулал олгох:

6.1.Тэмцээний дүнг гаргахдаа тасгийн гүйлтийн цэвэр цагаас шагналын хугацааг хасаж, торгуулийн хугацааг нэмэх журмаар хамгийн бага цагаар байр эзлүүлнэ.

6.2. I дугаар шатны шалгаруулалтын шагнал урамшууллыг аймгийн ЗДТГ хариуцна.

6.3. 1 дүгээр байр - Өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал

2 дугаар байр - Өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал

3 дугаар байр— Өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал

Аймгийн Засаг даргын 2022
оын .04 дүгээр сарын 05. –ны
өдрийн 1/1 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулах аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг явуулахад дараах дасгал, нормативуудыг хийж гүйцэтгэнэ.

НЭГ ”ГАРААНЫ ӨМНӨХ АЖИЛЛАГАА”:

Тэмцээнд оролцох тасаг нь гарааны өмнө шүүгчээс өгөгдсөн даалгавар, дасгал, нормативыг тогтоосон байр, талбайд бүрэн бүрэлдэхүүнээрээ биелүүлнэ. Тасгийн захирагч нарын тэмцээнд туслах гишүүн оролцож болно.

А.”Жагсаалын үзүүлэх тоглолт”:

Жагсаалтын үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана. Жагсаалын үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-7 минут байна.

- 1.Зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн,
- 2.Ёсолж хүндэтгэх, жагсаалаас гарах, жагсаалд орох, захирагч /дарга/-д очих, илтгэх, буцах ажиллагаа,
3. Тасгийн жагсаалын жигдрэлт:
4. Жагсаал удирдах дохио,
5. Жагсаалын дуу.

Тасаг бүр Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний сүлд дуу (Хөгжим Т.Мөнхтунгалаг, Шүлэг Г.Ганбат)-г заавал сурсан байхаас гадна, тасгийн захирагч доорх 10 жагсаалын дуунаас 1 жагсаалын дууг сугалж, дууг тасгийн бүрэлдэхүүнээрээ дуулна. Үүнд:

1. “Манай цэргийн жавхаа” Хөгжим Ш.Гунаажав, Шүлэг Б.Жалбуу
2. “Монгол Улсын төлөө зүтгэе” Хөгжим Б.Нямдорж, Шүлэг Г.Пүрэвдорж
3. “Энхийн үйлсэд Монгол цэрэг” Хөгжим Т.Насанбуян, Шүлэг Г.Баатарнум
4. “Дэлхийд данстай Монгол цэрэг” Хөгжим О.Эрдэнэцог, Шүлэг Г.Ганбат
5. “Баярын жагсаал” Хөгжим Г.Ганбат, Шүлэг Г.Ганбат
6. “Торгон хилийн зүг” Хөгжим Т.Чимэддорж, Шүлэг Ш.Сүрэнжав
7. “Цэргийн тухай дуу” Хөгжим Д.Дашням, Шүлэг С.Дашдооров
8. “Жанжин тугийн намираа” Хөгжим Т.Мөнхтунгалаг, Шүлэг Т.Бат-Очир

9. "Түүхт хил" Хөгжим Л.Мөрдорж, Шүлэг З.Пунцаг
10. "Улаан туг" Ардын журамт цэргийн дуу

Үнэлэлт: Жагсаалын үзүүлэх тоглолтын дүнг гаргахдаа Тасгийн захирагчийн жагсаал удирдах ур чадвар, жагсаалын элементийн гүйцэтгэл, тасгийн жигдрэлт, сургагдсан байдлыг тооцон үзүүлэлт тус бүрд 5 минут хүртэл шагнал өгнө. Үнэлгээг үндсэн 5 үзүүлэлтийн нийлбэрийн дунджаар бодож хугацааны шагнал өгнө. Жагсаалын явц дахь алдаа бүрд 20 секундийн торгууль онооно.

Б."Тасгийн захирагчийн тэмцээн":

Тасгийн захирагч дүүжинд суниах элементийг зөв, цэвэр гүйцэтгэнэ. Дасгалыг 20-оос дээш гүйцэтгэвэл 5 оноо, 17-19 гүйцэтгэвэл 4 онооны шагнал, 14-16 удаа гүйцэтгэвэл шагнал, торгуульгүй, 13-аас доош гүйцэтгэвэл 5 онооны торгууль онооно.

В."Биеийн тамирын нормативын тэмцээн":

Тасаг бүрээс эрэгтэй эмэгтэй тус бүр 1 хүүхэд сугалаагаар биеийн тамирын нормативыг гүйцэтгэнэ.

Эрэгтэй гишүүн гар дээр суниах дасгалыг 2 минутын хугацаанд 45 хүртэл гүйцэтгэвэл 0 оноо, 46-50 гүйцэтгэвэл 1,5 оноо, 51-55 гүйцэтгэвэл 3 оноо, 56-60 гүйцэтгэвэл 4,5 оноо, 61 түүнээс дээш гүйцэтгэвэл 5 оноогоор дүгнэнэ. Суниалтыг зөв, цэвэр гүйцэтгэх бөгөөд буруу болон дутуу суниалтыг тоолохгүй.

Эмэгтэй гишүүн гэдэс таталтын дасгалыг 2 минутын турш гүйцэтгэх ба 40 хүртэл гүйцэтгэвэл 0 оноо, 41-45 гүйцэтгэвэл 1,5 оноо, 46-50 гүйцэтгэвэл 3 оноо, 51-55 гүйцэтгэвэл 4 оноо, 56 түүнээс дээш гүйцэтгэвэл 5 оноогоор дүгнэнэ.

Г.Цэргийн 16 тоот гимнастикын 1,2 дугаар комплекс дасгал:

Тасгийн бүрэлдэхүүн цэргийн 16 тоот гимнастикийн 1, 2 дугаар комплекс дасгалыг 2 удаа бөмбөрийн цохилтонд гүйцэтгэнэ. /Хөгжмийн ая ашиглаж болно/ Тасгийн жигдрэлт, дасгалын гүйцэтгэлээр нь дасгал тус бүрийг 5 хүртэлх оноогоор дүгнэнэ.

Д."Тасгийн мэндчилгээ":

Мэндчилгээг тасаг бүр урлагийн зохиомжит тоглолтыг 10 минутын хугацаанд гүйцэтгэхээр урьдчилан бэлтгэж ирсэн байх бөгөөд эх оронч үзэл, төлөвшлийг сурталчилах зорилгын дор сургууль, багийн онцлогийг харуулсан 5-8 минутын хугацаатайгаар бэлтгэн үзүүлнэ. /хөгжим, ая, понаграмм ашиглан ганцаарчлан болон тасгаар оролцож болно/. Мэндчилгээг 5 хүртэлх оноогоор дүгнэнэ

ХОЁР. “МАРШ, ГҮЙЛТИЙН ТЭМЦЭЭН”

Маршид тасгийн нийт бүрэлдэхүүн 3 км замыг туулна. Тасгууд сугалааны дарааллаар шүүгчийн дохиогоор 15 минутын зайтайгаар гараанаас гарч “гранат мэргэн шидэлт”, “мөлхөлтөөр газар орныг туулах”, “эмнэлгийн норматив”, “байр зүйн цэг”-үүдэд нормативыг тус тус гүйцэтгэнэ.

Норматив гүйцэтгэх цэг бүр дээр тасгийн бүрэлдэхүүн бүрэн ирсний дараа нормативыг эхлэх команд өгнө. Тасгийн хамгийн сүүлийн хүн нормативыг хийж дууссаны дараа маршийг цааш үргэлжлүүлнэ.

Нэгдүгээр цэг: “Гранат шидэлт”:

Тамирчид тус бүр Ф-1 маркын 600 грамм жинтэй нэг гар гранатыг эрэгтэй сурагчид 25 м зайтай онооны тойрогт, эмэгтэй сурагчид 15 м зайтай заагт шиднэ.

Үнэлэлт- Тойрогт оносон тохиолдол бүрт 30 секундын шагнал харин тойргоос дутаасан болон гадна талд шидсэн тохиолдол бүрт 30 секундын торгуультай.

Хоёрдугаар цэг: “Мөлхөлтөөр газар орныг туулах”:

Бэлтгэгдсэн заагт ирмэгц тасаг нэг эгнээнд орж 30 м газрыг мөлхөлтөөр туулна.

Үнэлэлт: Нормативын биелэлт буюу газар орныг мөлхөлтөөр туулах үеийн хугацааг эхний хүн гүйцэтгэж эхэлснээс сүүлийн хүн дуусах хүртэлх хугацаагаар тооцож онц 1 мин, сайн 30 секундын шагнал, муу үнэлэгдсэн бол 1 мин торгуул ноогдуулна. /онц-2 минут, сайн-2 мин 20 сек, дунд-2 мин 30 сек/

Гуравдугаар цэг: “Эмнэлгийн норматив”:

Тасгийн эмнэлгийн зааварлагч, шүүгчийн томилсон тасгийн нэг гишүүнтэй хамт шархтанд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж, Цэргийн хүн эмнэлгийн бэлтгэлийн 3 дугаар норматив /цус гоожилтыг тогтоогч резин чангалуурыг гуянд тавих/, 5 дугаар норматив /биеийн дээд болон төгсгөл хэсгийн яс хугарах үед гарын доорх материалаар чиг тавих/-ыг гүйцэтгэн шархтныг аюулгүй зайд татан гаргаж, эмнэлгийн байранд хүргэнэ.

Үнэлэлт: Эмнэлгийн нормативыг “онц” биелүүлбэл 1 минут, “сайн” биелүүлбэл 30 секундээр шагнаж, “муу” биелүүлбэл 1 минутаар торгоно.

Дөрөвдүгээр цэг: “Цэргийн байр зүйн норматив”:

Тасгийн захирагч шүүгчээс цэгийг сугалан луужин ашиглан 2 цэгийг олно. 1 цэг дээр дараагийн цэгийг байрлуулсан байна. 4 минутын хугацаанд 2 цэгийг олсон бол 2 минут, 1 цэгийг олсон бол 1 минутаар шагнаж, хугацаандаа багтаж олоогүй

бол 1 минутаар торгоно. Мөн цэгийг олох оролдлого хийгээгүй тохиолдолд 3 минутаар торгож, 4 минут барина.

ТЭМЦЭЭНИЙГ ДҮГНЭХ:

Гарааны өмнөх ажиллагааны нийлбэр дүнг 10 секундээр үржүүлэн оноог хугацаанд шилжүүлэн тооцно.

Тасгийн 3000 метрийн гүйлтийн цэвэр цагаас маршрутын замд хийгдсэн нормативуудын шагналын оноог хасч, торгуулийн хугацааг нэмж маршийн дүнг гаргана.

Тэмцээний нийлбэр дүнг гаргахдаа маршийн хугацаанаас гарааны өмнөх ажиллагааны нийлбэр дүнг хасах журмаар хамгийн бага хугацаагаар байр эзлүүлэн дүгнэнэ.